

#### IV. Монголын улс төрийн түүх

### МОНГОЛЧУУДЫН УЛС ТӨРИЙН СОЁЛ: ТҮҮХ, ОРЧИН ҮЕ

Ё. Довчин

Монгол Улсын Их Сургууль. Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль. Улс төр судлалын тэнхим.

*Өгүүллийн товч утга:* Олон зууны туршид бүрдсэн монголын төр ёсны уламжлал, улстөрийг ойлгох, түүнд хандах монгол хүний өвөрмөц онцлогийг судлахгүйгээр улстөрийн шинжлэх ухааны дэлхийн жишгийг авч хэрэглэх нь бүтэл муутай байх болно. Иймд ардчилалд шилжихэд улстөрийн тогтвортой байдлыг хангах, улстөрийн ардчилсан чиг баримжаа, үйл байдлыг нийгмийн гишүүдэд төлөвшүүлэн улстөрийн нийгэмшлийг хангаж өгөхөд улстөрийн соёлын хүчин зүйл нэн чухал. Үүнийг иш үндэс болгож тус өгүүлэлд монголын уламжлалт улстөрийн соёл, түүний үнэт зүйлс, залгамж холбоо, хувьсал өөрчлөлтийн явцыг харуулж. энэ хүрээнд өнөөгийн нөхцөлд нийгэмд тулгамдаж байгаа зарим асуудлуудад уншигчдын анхаарлыг хандуулахыг зорьсон болно.

*Түлхүүр үг:* үнэт зүйлс, чиг баримжаа, үйл байдал, эрх чөлөө, дэг журам, төрт ёс, ардчилал, зах зээл

Америкчууд эх орноороо бахархах дуртай, япончууд улстөрийн дээд тушаалтнуудаа хүндэлдэг, францчууд тэрс үзэл, бослого тэмцлээс буцдаггүй гэж ярилцдаг нь үндэстэн бүрийн соёлын хэм хэмжээ улстөрийг хэрхэн өвөрмөц дүр төрхтэй болгодгийн жишээ мөн.

Улстөрийн соёл бол ард түмний үндэсний нийт соёлын салшгүй хэсэг байдаг учир тухайн нийгмийн улстөрийн бүтэц зохион байгуулалт, үйл явц, үйл байдалд гарцаагүй тусгалаа олж байдаг нь зүй ёсны хэрэг. Тухайлбал, улс оронд ардчилал хөгжиж хөлөө олох нь улстөрийн соёлын уламжлал, өөрчлөлттэй шууд холбоотой. Нөгөө талаар улстөрийн соёл улстөрийн субъектив хэмжүүр болохын хувьд судалгааны таамаглал дэвшүүлэх, шалгахад тайлбар өгөх чухал ухагдхуун болж өгдөг.

Америкийн эрдэмтэн Алмонд, Верба нар хэд хэдэн үндэстнүүдийн улстөрийн соёлыг харьцуулан судлаад "өвгийн", "албатын", "оролцооны" [Almond, 1963, p.18] гэсэн улстөрийн соёлын нийтлэгдүү хэв маягууд байж болохыг тодорхойлсноороо уг үзэгдлийг шинжлэх ухааны үүднээс судлахад том алхам хийсэн юм. Тэд бүх иргэдийн улстөрийн идэвхтэй оролцоо, рациональ хандлагыг иш үндэс болгосон ардчиллын загвар хамгийн амжилттай байдаг гэж үзэхийн сацуу "Ухамсартай идэвх оролцооны тэр загвар нь иргэний соёлын зөвхөн нэг л бүрдүүлбэр учир логикийн хувьд түүнээс тогтвортой ардчилсан засгийн газар гарах боломжгүй. Тогтвортой ардчилал гагцхүү зарим утгаар өөрийн эсрэг талууд, тухайлбал, идэвхгүй байдал, сүсэг бишрэл, засаглал, эрх мэдэлд хүндэтгэлтэй хандах мэттэй нийлж нэгдсэн цагт л боломжтой болно" [Almond, 1963, p.12] гэжээ. Иймд ардчилсан нийгэм, түүний улстөрийн соёл олон янзын дэд соёлуудаас, тухайлбал, уламжлалт ба срчин үеийн, өрнийн ба дорнын гэх мэтээс бүрдэх аж. Тэгвэл шинэ улстөрийн соёл төлөвшүүлнэ гэдэг нь эдгээрийн дотроос аль нэгийг нь сугалан авч "зүтгүүлэх" хэрэг биш бөгөөд харин дэд соёлуудыг "синтезлэх" замаар түүнийг бүрдүүлнэ гэсэн үг болох нь. Монголд ч бас иймэрхүү л улстөрийн соёлын зураг харагдах бөгөөд өнөөгийн монголын улстөрийн соёл холимог шинжтэй хийгээд хувь хүн, хэсэг бүлэг, нийгмийн төвшинд ч улстөрийн соёлын хэв маягууд харилцан адилгүй хэмжээ, харьцаатай оршин байдаг нь ойлгомжтой. Чухамхүү үүнийг иш үндэс болгож миний бие санаагаа гаргах гэж оролдсон болно.

Юуны өмнө монголчуудын улстөрийн соёл дорнын уламжлал, нүүдлийн соёл иргэншлийн түүхэн онцлогтой уялдан суурьшмал болон газар тариалангийн

соёлоос өвөрмөц шинжээрээ ялгардаг [Е.Довчин, 2000, 26-28, 55-58 талд үз]. Тал нутгийн нүүдэлчин ард түмний байгаль-цаг уур, түүх, аж төрөх ёс, ертөнцийг үзэх үзэлтэй холбоотойгоор тэдний улстөрийн төсөөлөл, итгэл үнэмшил, үнэт зүйлс төлөвшиж бий болсон. Монголчууд эрт үеэс эзэн хаанаа тэнгэр язгууртай, албат харъяатуудаа хураан захирахаар заяагдсан хэмээн итгэж төрөө дээдлэн шүтдэг нь тэдний улстөрийн соёлын тулгуур үнэт зүйл болон бэхжсэн байдаг. Хэрэв улстөрийн соёлыг иргэдээс улстөрийн систем, төрдөө хандах чиг баримжаа гэж үзэхүл "Төрийн сүлд минь өршөө" хэмээх залбирал монголчуудын төрдөө хандах хандлагын цогц илэрхийлэл болдог нь мадаггүй.

Монгол хүн түүхийн олон зууны ээдрээт замыг туулан өвөрмөц төр ёсоо бий болгохдоо төрийг хүчирхийллийн, эсвэл ашиг арилжааны хэрэгсэлд үл тооцож, харин ч авран хамгаалагч, шударга мөрийн үлгэр жишээ хэмээн төсөөлж ирсэн нь уул улстөрийн соёлын нэг онцлог мөн. Ийнхүү төрд биширч, улмаар хүчтэй, төвлөрсөн төрд тал өгч байсан нь "деспотыг" мөрөөдсөндөө бус, харин нүүдлийн ахуйгаас улбаатай байгаль-газар зүйн хийгээд ах зах, ихэс дээдэс, ёс жудагаа хүндэтгэн дагадаг нийгэм-соёлын хүчин зүйлсийн нөлөөнөөс болсон бизээ. Эзэн Чингисийн үеэс төрдөө үнэнч шударга зүтгэх нь монгол хүн бүрийн амьдралын ердийн хэм хэмжээ болж байсныг түүхэн сурвалжаас өнөө бид мэдэх бөгөөд энэ нь улмаар үүргийн өндөр мэдрэмжийг улстөрийн соёлд "суулгаж" өгсөн гэж болно.

Монголчуудын суурь улстөрийн соёлд нүүдлийн аж төрөх ёсноос гарвалтай айлсан нутаглах, аж ахуйгаа хамтран эрхлэх, харилцан туслах мэт "айл хүний амь нэг" хамтын шинж түлхүү тусч, явцуу ашиг сонирхлоороо хуваагдан өрсөлдөхөөсөө хүний ёс, эрхэмлэл, үнэт зүйлсийг чухалчилж бусдын төлөө үзлийг амин хувиа хичээхээс, үүрэг хариуцлагыг эрх ямбаас дээгүүр тавих нь уламжлал болсон юм.

Домог, шашин, бэлэгдэл ёс монголын улстөрийн соёлын салшгүй бүрэлдхүүн мөн. Ийнхүү бүхэлд нь авч үзвэл, уг соёл ёс зүй-үнэт зүйлсийн чиг баримжааг төвд тавьж, нийгмийн харилцааг зохицуулагчийн хувиар ёс суртхуун, хууль эрх нэг зиндаанд өргөмжилж, нэг үгээр ёс зүй нь хуулийн хүчинтэй байсан гэж болно.

Алмонд хожмын нэг бүтээлдээ: "Нийгмийн ангиуд, шашин, үндэс угсаатны бүлгүүдийн рациональ ашиг сонирхол бол түүхэнд даацтай хувь нэмэр оруулдаг улстөрийн хөдөлгөөн, мөргөлдөөний хүчирхэг хөдөлгүүр болдог нь мэдээжийн хэрэг. Гэхдээ эх оронч үзэл, уугуул бүлэгтээ үнэнч байх чанар, шашны үнэт зүйлс, түүнчлэн ердөө л зуршил, уламжлалууд зэргийг улстөрийн бүтэц, легитимийг тайлбарлах хүчин зүйлсийн тооноос хасах аргагүй" хэмээн нотолсон байдаг нь дээр дурдсантай санаа дүйж байна [Almond, 1980, p.20].

Эв эеийг хичээх нь монголын улстөрийн соёлын тулгуур үнэт зүйлсийн нэг мөн. Монголчууд маргалдах сөргөлдөх, эвдрэлцэхийг уруудаж доройтохын цондон хэмээж, төр түмний хэргийг эв зүйгээр, уужуу тайвуу ухаан зарж шийдэхийг эрхэм болгодог. Түүхийн хүнд бэрх цагт ингэж хандаж байсан жишээ олон байдгийн хамт [Насилов, 1987, 12 талд үз] ардын аман зохиолын баялаг сан үүнийг төвөггүй баталдаг билээ.

Монголын төр ёсны нэг онцлог нь дэг журмыг чухалчилж, эхлэх цэг нь гадаадын нэгэн зохиолчийн бичсэнээр монголчуудын эхийн сүүтэйгээ хамт хөхсөн төмөр мэт сахилга байсан [Уолкер, 1998, с.37] агаад үүний ачаар монгол төрийн сүр хүчийг дэлхий дахинаа бишрүүлж байсан удаатай. Иймд эрх чөлөө, дэг журам хэмээх үнэт зүйлс монголчуудын улстөрийн соёлд эн зэрэгцээ тавигдаж иржээ.

Ер монголчуудын хувьд улстөр ердөө л засгийн эрхийн төлөө тэмцэл төдий бус, харин хүмүүн нийгэм зохион байгуулагдах жам ёсны тухай гүн ухаан,

төрийн тухай үзэл сургаал, даган мөрдөх үнэт зүйлс, бишрэн тэмүүлэх чин хүслэнгийн цогц байж, тэнгэрийн үзэлд хураангуйлагдан суурилж байсан гэлтэй.

Аливаа үндэстний улстөрийн соёлын үнэт зүйлс, уламжлал, хэм хэмжээ нь харьцангуй тогтвортой байдаг хэдий ч улстөрийн соёл бас огт өрчлөгддөггүй зүйл биш ажээ. Шинэ үйл явдлууд, амьдралын шинэ хэв маяг хувь хүний хандлага, төсөөлөл, итгэл үнэмшлийг өөрчилнө. Үүний адил монголчуудын улстөрийн соёл түүхийн турш хувьсан өөрчлөгдсөөр ирсэн нь лавтай.

70-аад оны дундуур эхэлсэн гэгддэг ардчиллын "гуравдагч давалгаа" 90-ээд он гэхэд дэлхий дахиныг улам бүр өргөн хамарч монгол орон ч түүний гадна үлдэж хоцроогүй билээ. Ийнхүү ардчилалд хөл тавьсан монголчуудын улстөрийн соёл сүүлийн 10 гаруй жил өрнөжих үйл явц, ардчилал, зах зээлийн нөлөө дор гүнзгий өөрчлөгдөж байгааг сэтгэлгээ, ахуй орчин гэрчилнэ. Өрнөжих нь бидний хувьд гэнэт гарч ирсэн цоо шинэ үзэгдэл биш. Монгол улс хорьдугаар зууны ихэнхэд дамжсан модернизаци өрнөжих үйл явцын нэг л хэсэг нь байв. Марксизм ч барууны бүтээгдэхүүн, социализм ч мөн л тэндхийнх. Өнөөдөр нийгмийн шинжлэх ухааны парадигмын шилжилтийн тухай мундахгүй ярьж, бичиж байгаа хэдий ч уг чанартаа бид өрнөжих үйл явцын хүрээн дотор тэгэхдээ ардчилалд шилжих үйл явцыг туулж явна. Өнгөрсөн далан жилийн модернизацийн үр дүнг бид наанатай, цаанатай авч үзэх нь гарцаагүй ч харин өнөөгийн шилжилт түүнээс тэс өөр гэдэг нь нэгэнт илэрхий болсон. Мэдэхгүй чадахгүй, эсвэл мэдэмхийрэхийн харгайгаар улстөрийн огцом эргэлтүүд дээр барьц алдан бишгүйдээ алдаж онож ирэв. Гэхдээ бидэнд өөр сонголт байхгүй, хэдийгээр сул тал нь зөндөөн ч ардчиллаас илүү сайн дэглэмийг олоход бэрх гэдгийг хүн амын дийлэнх ухамсарлаж ойлгосон нь улстөрийн соёл шинэчлэгдэх суурь нөхцөл болсон гэж болох юм.

Энэ үеэс нийгмийн амьдрал эрчтэй өөрчлөгдөж, түүний дотор улстөр, басхүү монголчуудын улстөрийн соёлын үнэт зүйлс, хэм хэмжээ, үйл байдлын хэв загварууд хувьсан өөрчлөгдөж байгаа ч аажмаар өөрчлөх, өөрчлөгдөх, бас ч хадгалж үлдэх үнэт зүйлс цөөнгүй байгаа нь илэрхий болсоор байна.

90-ээд оны эхээр нийгэм-эдийн засагт хуримтлагдсан асуудлууд, хүнд сурталт тогтолцоо, удирдлагын арга барилыг шүүмжлэх, ил тод байдлыг бүх хүрээнд хэвшүүлэхээс эх авсан хүмүүсийн улстөрийн оргилсон идэвх сөрөг хүчин, чөлөөт хэвлэл, шинэ нам, эвсэл холбоо, жагсаал цуглаан, өлсгөлөн, суулт зэрэг улстөрийн оролцооны дасч дадаагүй шинэ шинэ хэлбэрүүдээр илэрч гарсан юм. Энэ бүхэн улстөрийн урьдын хэвшмэл ойлголт, төсөөллийг эвдэж, иргэд улстөр гэдэг бол "тэртээ дээр хааны титэм" дээр гялалзах халдаж зүрхэлшгүй зүйл биш, харин хүмүүсийн өдөр тутмын амьдрал, ашиг сонирхол мөнийг ухаарч, хүн бүрийн шахам улстөрд оролцох, өөрийн үзэл бодол, байр сууриа илэрхийлэх эрмэлзэл, мэдрэмж сэргэсэн нь улстөрийн чиг баримжаа, үйл байдалд эргэлтийн шинжтэй өөрчлөлт гарахад нөлөөлснөөс гарцаагүй.

Ялангуяа монголын нийгэмд анх түрүүн төр, иргэний нийгэм хэрэг дээрээ зааглагдаж, улмаар Улс Төрийн Товчооны огцролт, Цэдэнбал, дээд удирдлагыг хурц шүүмжилсэн нь явсаар монголчуудын хэзээнээс "хаандаа халддаггүй" уламжлалыг "ганхуулж", төрийг үзэх үзэл хийгээд тухайн улстөрийн дэглэм, төр хийгээд төржсөн намыг ялган салгаж ойлгоход хүргэсэн гэх үндэстэй. Тодруулбал, нийгмийн янз бүрийн бүлэг, давхаргуудын үзэл бодол анх удаа ноёрхогч үзэл сурталтай эн тэнцүү тавигдаж өрсөлдсөн нь гагцхүү ардчилах үйл явц баттай эхэлснийг баталсан хэрэг. Энэ бүхэн нийгмийн бодит ахуйгаа дахин эргэж ул суурьтай эрэгцүүлэн тунгаахад зайлшгүй хүргэсэн нь үнэн. Энэ үйл явцад улстөрийн соёлын доторхи ардчиллын гэмээр дэд соёлын татах хүч яах ийхийн зуургүй нэмэгдэж, үйл явцын хөтөлгөч нь болж байв.

Гэвч олон түмэн огцом улстөржиж, зарим хэсэг хэт хувьсгалчирхснаас улстөрийн тэмцэл улам бүр сэтгэл хөдлөл, хөөрлийн гүн тийш нэвтэрсээр байсан

эгзэгтэй мөчид монголчуудын улстөрийн соёлын уламжлалт үнэт зүйлс тухайлбал, эв эеэ хичээх, төр ёсоо хүндэтгэх, хүлээцтэй, уужуу тайвуу монгол ухаанаар хандах зэрэг нь үйл явцыг тогтоон барьж зөв голидролоор нь залахад чухал хүчин зүйл болж байсан нь илт билээ. Үүний нэг баталгаа нь засгийн эрх мэдэл улстөрийн нэг хүчнээс нөгөөд тайван замаар шилжиж чадаж байсан явдал юм. Хүн амын ихэнх хэсгийн улстөрийн тэмүүлэл харьцангуй тогтвортой байсан нь "улстөрийг зохих хүрээнд барихад" дөхөм болсон талтай. "Ардын эрх" сонины 1990 оны 244-р дугаарт нийтлэгдсэн санал асуулгын дүнгээс үзэхэд "Та улстөрийн нам, хүчнүүдээс зохион байгуулж буй арга хэмжээнд байнга оролцдог уу?" гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 13 хувь нь тийм, 46,7 хувь нь хааяа, 37,3 хувь нь оролцдоггүй гэж хариулсан байдаг.

Гэсэн хэдий ч тал нутгийнхны омог бардам, туйлшрамтгай, дарвиж дууриадаг чанар улстөрийн дүрэлзсэн "гал" дээр тос нэмж байсныг хэлэхгүй өнгөрч боломгүй. Тухайлбал, удирдлагаа огцруулах, өөрчлөх кампани бүх шатанд өрнөж ажил хаялт, суулт, өлсгөлөн, өргөх бичиг нэг үе "шалгарсан арга" болсон байв. Үүний үр дагавар болж төрийн байгууллагын эрч хүч шат шатандаа саарч, үүний хажуугаар ардчилал, эрх чөлөөг хэн юу хүссэнээ хийж болох мэт ойлголт газар авснаар нийгэмд сахилга, дэг журам алдагдаж энэ бүхэн нь "засаглалын хомсдол" хэмээн нэрлэгдсэн юм.

90-ээд онд монголчуудын улстөрийн зан араншин бараг үндсээ хүртэл ил гарсан гэж хэлж болно. Энэ байдал дунд ардчилалд нийцэж тохирох үйл байдлын хэв загварууд байхад үл нийцэх нь ч бас байв. Жагсаал цуглаан, өлсгөлөн, ажил хаялт, огцруулалт, нам эвсэл холбоо, сүм хийд, мэрэг төлөгчид, уул овооны тахилга мэт эрээн мяраан үзэл бодол, зан үйл шил шилээ даран орж ирсэн нь нэг талаас хүмүүсийн улстөрийн идэвх, олон ургальч үзэл, ашиг сонирхлын ялгаралтай холбоотой байсан хэдий ч нөгөө талаас монголчуудын аливаад туйлшрамтгай хатуу хэвийг/стереотип/ ямар нэг байдлаар харуулж өгсөн юм. Хүний эрх, эрх чөлөө л гэсэн бол захирах захирагдах ёс, ерөөс алив засаглал, удирдлага, зохион байгуулалтыг үгүйсгэх, хүнд сурталт тогтолцооны төржсөн намыг шүүмжилсэн бол ерөөс ямар ч намыг "үзэхгүй болох", ноёрхогч үзэл суртлыг халсан бол ерөөс аливаа "изм"-үүд хэрэггүй гэх мэт аяглах нь туйлшрал, бас төөрөгдөл байв. Аль нь ч бай "Хэрэв бид хэт туйлшралд автагдаагүйсэн бол жинхэнэ ардчиллын үр шимийг хүртэж, өнөөгийнхөөс олон дахин илүү амжилтад хүрэх байлаа" [Б.Даш-Ёндон, 1999, 17дахь тал] гэдгийг зөвшөөрөхөөс аргагүй.

Түүнчлэн хүн амын үлэмж хэсэг дуу дуугаа авалцан гарч ирсэн олон намуудын санал зөрөлдөөн, парламентын эх адаггүй маргаан мэтгэлцээн, тэр ч атугай нэг намаас нөгөө рүү "гүйгчдэд" хүртэл таатай биш хандаж байсан нь аливаа зөрчил сөргөлдөөнийг задрал бутралын дохио хэмээдэг, төр, шашин үндсээсээ урван тэрслэхийг цээрлэж ирсэн мөнөөх үндэсний сэтгэлгээний хатуу хэвтэй холбон тайлбарлаж болох биз ээ.

Энэ нь нэг талаас өрнийн нийгэм ихэнхдээ иргэний нийгэм, зах зээлд тулгуурлаж байдаг бол дорно дахинд төрийн үйлдвэрлэлийн арга давуутай байдаг зүй тогтлыг тэр бүр анзаарч үзээгүйтэй хслбоотой ажээ. Нөгөө талаас зах зээлийн хийгээд этатист улстөрийн соёлын хоорондын зөрчлийг шийдвэрлэхтэй ч бас уялдаатай байв.

Улстөрийн эрс өөрчлөлт нийгмийн тогтворгүй байдлыг бий болгож, нийгмийн амьдралын гол хүрээнүүд, тэр дундаа эдийн засагт ноцтой нөлөөлөв.

Гэвч амьжиргааны төвшин буурсан хэдий ч нийгмийн гишүүдийн ихэнх нь өөрчлөлт шинэчлэлээс нүүр буруулаагүй нь "сонин". Тухайлбал, 1996 онд ардчилал зах зээлийн нэлээд радикал шинжтэй хөтөлбөр дэвшүүлсэн улстөрийн шинэ хүчинд сонгогчдын олонхи саналаа өгсөн нь үүний нэг жишээ гэж болно. Улстөрийн ааг омог аажимдаа намдуу аястай болсныг хүмүүс улстөрийг огт

хэрэггүй гэж үзсэндээ ч бус, харин зах зээлд шилжих бодит бэрхшээл, ардчиллыг ганцхан амьжиргаа сайжруулах арга хэрэгсэл мэт ойлгох нь өөрчлөгдөж эхэлсэнтэй холбож үзэж болох юм. Судалгаанаас үзэхэд өнөөдөр ч дөрвөн хүн тутмын нэг нь улстөрийн амьдралд идэвхтэй оролцоход бэлэн байдаг ажээ.

90-ээд онд болж өнгөрсөн сонгуулиуд монголын улс төрийн чиг баримжаа, үйл байдлын өөрчлөлтийг тодорхой хэмжээгээр тусгасан байна. Онцолж тэмдэглэхэд Монголд сонгуулийн кампани бүрийн явцад олон түмний сэтгэл зүйг залсан өвөрмөц маягийн сэдээгч давалгаа бий болж тэр нь тухайн үед энэ л хүнийг сонгох нь зөв гэдэг рүү сонгогчдыг хөтөлдөг, энэ нь ч сонгуулийн дүнг "савалгаатай" болгоход чамгүй нөлөөлдөг нь ажиглагддаг [ Ё.Довчин, 2003, 8-9 дэх талд үз].

Монголын улс төрийн соёл "зах зээлчлэгдэж" байна. Зах зээл бол өрсөлдөөн, хувь хүний эрхийг онцолсон, бусдыг тэтгэж бөөцийлөхийг дэмждэггүй үзэл санааг соёлын орчинд оруулж ирдэг нь маргаангүй. Гэвч монголын 90-ээд оны бодит байдал дээр зах зээл сонгодог чөлөөт эдийн засгийг бус, харин хар захыг санагдуулах нь олонтаа. Энэ нь юуны өмнө хууль бус наймаа, хялбар аргаар хөлжих, түр зуурын ашиг хонжоо хөөцөлдөх, улсын өмч, төсвийн хөрөнгийг хуйвалдан завших, луйвардах явдлаар илэрч байв. Компаниудын бизнес дистрибьюторын үүргээс төдийлэн хэтрэхгүй, ихэвчлэн үйл ажиллагаа нь компрадор шинжтэй байгаа нь нууц биш билээ. Бизнесийн давхаргад танил тал, садан төрөл, нам бүлэг, нутаг усны хэлхээ сүлбээ хүч авч, улмаар төрийн алба, бизнес хутгалдах нь хэвийн үзэгдэл болов. Ийм байдлыг дагаад олон хүн өөрийгөө ёс суртхууны аливаа хорио, хязгаарлалт, нийгмийн үүргээс чөлөөлж, ямар ч үнэ цэнээр атугай баяжих бэлжих санаархалд хөтлөгдөх болжээ.

Барууны индивидуал үзэл монголчуудын үнэт зүйлсийн системд нөлөөлөх нь лавтай. Хувь шинжийн үзэл монголчуудын сэтгэлгээнд дээр үеэс огт байгаагүй гэх аргагүй. Гагцхүү түүний өвөрмөц онцлог нь айл саахалтынхны ойр дотно, эвсэг харьцаа, харилцан туслах, хөдөлмөрөө хоршиж хамтран ажиллах, бусдын үйл хэргийг эхлэн бүтээх, нэр төрөө бодох, нөхөрлөл түншлэлдээ үнэнч найдвартай байх зэрэг төрөл садан, нутаг усаараа нэгдсэн нийтлэгүүдээрээ амьдардаг нүүдэлчдийн аж төрөх ёсноос урган гарсан хэм хэмжээнүүдтэй шүтэлцсэн байдаг оршино. Иймд монголын нөхцөлд индивидуал үзэл үнэт зүйл-ёс суртахуун, хэм хэмжээ давамгайлсан улстөрийн соёлд зохицон дасч байж сая нийгэмд нааштай чиг үүрэг гүйцэтгэх болно.

Зах зээлийг бүтэхгүй болгонд буруутгахгүй нь мэдээж. Гэхдээ энэ нь нийгмийн болоод хувийн бүх харилцаанд зах зээлийн хууль дангаараа ноёрхох ёстой гэсэн хэрэг хараахан биш юм. Өөрөөр хэлбэл, "Хэрэв зах зээл хүний амьдралын бусад бүх хүрээг өөртөө "империалист" маягаар захирч, зөвхөн өөрийнхөө хил хязгаар дотор зөв зүйтэй байдаг иррациональ шинж, хэм хэмжээ, шалгуурыг тулган хүлээлгэх нь шударга бус" байх ажээ. [Капустин, 1992, с.93].

Улс төрийн соёл дахь үнэт зүйлсийн систем өөрийн дотоод логик, онцлог, зорилгынхоо дагуу өөрчлөгдөх чадвартай байдаг байна. Иймд уламжлалт ёс суртхууны хэм хэмжээнүүдийг индивидуал хэмжүүрээр хэмжиж "хасч танах", эсвэл хүчээр солих нь улстөрийн зөв эвэргүү шинэ соёл төлөвшихөд таагүй нөлөөлөх болно. Социализмын он жилүүдэд гаднын соёлын үнэт зүйлийг албадан "шилжүүлэн суулгасны", мөн үзэл суртал, шашингүйн үзэл, хотжилтын үр дагавар болж монголчуудын нийгмийн харилцааг хэзээнээс зохицуулж ирсэн уламжлал, үнэт зүйлс, ёс заншил гээгдсний сургамжийг санах хэрэгтэй.

Аливаа нийгмийн үзэгдлүүдийг эргэцүүлэн тунгаахдаа монгол хүн улстөрийн соёлын суурь "инстинктээрээ" үнэт зүйл-ёс зүйн шалгуураар хэмждэг нь эргэлзээгүй. Иймээс нийгэмд гарч ирсэн ёс суртхуунгүй явдал, харш үзэгдэлд хүмүүс доош унасан амьжиргаанаасаа дутахааргүй санаа зовж явдаг нь үүнтэй холбоотой. 1996 оны судалгаанд оролцогчдын 74,4 хувь нь хар амиа бодох,

луйвардах, залилан мэхлэхийг нийгмийн сэтгэл зүйд бий болсон хамгийн олиггүй үзэгдэл гэсэн бол "Шилжилтийн үед таны үзэл бодолд ямар өөрчлөлт гарав?" гэсэн асуултад 42-46 хувь нь төр ёс, хууль тогтоомжийг дагаж мөрдөх, хүнийг хайрлах, бие биеэ хүндлэх нь суларсан гэжээ. Монгол хүний эрхэмлэдэг нэр төр, голч шударга, ажилч хичээнгүй зан, ахмад үе бусдыг хүндэтгэх, сэтгэл харамгүй, хүнлэг ёс, андгай тангараг, найз нөхөрлөлдөө үнэнч байх мэтийн сайн үйлүүд үнэт зүйлсийн системд тун доогуур эрэмбэлэгддэг болсон нь харагддаг. Иймээс ч хүмүүс хоорондын харилцаанд "Чи надад, тэгвэл би чамд" гэсэн заавал ч үгүй тэнцүү өгөө аваа нэхдэг зарчим мөрдөгдөж, улмаар хээл хахууль газар авах үүд хаалгыг нээж байна.

Тэгш байдал, нийгмийн шударга ёс, альтурист, эх оронч үзэл, ёс жудаг зэргийг илүүц дэмий яриа, нийтийн аливаа эхлэл санаачилгыг мэдрэл муутайн шинж гэх нь холгүй болж, үүний оронд наймаа панз, эдийн засгийн хяналтгүй байдал, амар хялбар амьдрал, эд мөнгөний шунал, хувиа хичээх нь бараг байж болох ердийн үзэгдэл болж хувирч байгааг судлаачид тэмдэглэсэн байдаг нь үнэний хувьтай. Түүний дотор бүхэнд гагцхүү хэрэглээний үүднээс хандах, тансаглах, биеийн жаргалыг шүтэх гедонист хандлага хүчтэй болж байгаа нь илт. Өнөөдөр ч хамгийн сэтгэл зовоосон асуудалд юуны өмнө архидалт, танхайрал, гэмт хэргийг хүмүүс нэрлэсээр байгаа нь төр иргэдийнхээ аюулгүй байдлыг хангах заяагдмал гэмээр үүргээ олигтой биелүүлж чадахгүй явсаар ирсний гэрч юм. Үүний зэрэгцээ нийгэмд биеэ үнэлэгчид, хог түүгчид, траншейныхан, тэнэмэл хүүхдүүд мэтийн этгээд бүлгүүд үүсэв. Ядуурал их байгаа нь үнэн боловч бүх зүйлийг тийшээ чихэж бас болохгүй. Ийм байдал угжирвал төрөө гэх иргэдийн итгэлд ан цав сууж, төр төр шиг байх байр сууриа эгүүлэн олоход илүү их хүч, цаг зарах нь мэдээж билээ.

Монголчуудын улстөрийн соёл сэтгэл хөдлөл-мэдрэмжийн онцлог шинжээрээ ялгарч, иргэд төрөө хүндэтгэх төдийгүй түүнээс айж эмээх мэдрэмж өндөртэй байсан нь дан ганц номхон доройн шинж биш ажээ. Иргэн төрөөсөө "гэрэвших" нь цаад утгаараа тохиолдлын, гэнэтийн халдлага аюулаас айж балмагдахаас ангижирч чаддагаараа "улстөрийн хүн" болдог тухай санааг Гобсс хэлсэн. Гэтэл нийгэмд эл мэдрэмж саармагжиж, захирах захирагдах ёсыг бараг илүүц мэтээр туйлширахад хүргэсэн. Өнөөдөр ялангуяа залуучуудын ухвар мөчид хэсэг өөрсдийгөө ёс суртахуун, соёлын уламжлалаас чөлөөтэй, айх ичих зүйлгүй мэт санаж, өнгөрсөн үеэ басамжлахын хэрээр нийгэм, төрийн институтууд, хэм хэмжээ өөрт нь огт падгүй мэт бодох болсон нь үүний урхаг юм. Энэ бүхнийг "социалист хууль ёс"-ны нимгэхэн давхарга, зузаан хэдий ч цагийн эрхээр элэгдэж хэврэгшсэн уламжлалт ёс суртхууны давхарга нэгэн зэрэг өөрчлөлтийн салхинд "идэгдэж", дороос нь хүн сүргийн шинжийг санагдуулам зан авир үе үе цухалзах болсноор тайлбарлаж болох мэт. Тухайн үедээ А.де.Токвиль "Хамгийн азтай газар зүйн байршил, хамгийн сайн хууль ч ноёлогч зан суртхууны хажуугаар үндсэн хуулийн оршин тогтнолыг хангаж чадахгүй бөгөөд харин зан суртахуунд түшиглэвээс хамгийн таагүй газарзүйн нөхцөл, хамгийн боловсронгуй бус хуулиудаас ч ашиг хүртэж болно" хэмээн бичснийг санахад илүүдэх юун [Токвиль, 1992, с. 22].

Өнөө үед Өрнө, Дорнын соёлын уулзвар дээр монголын улстөрийн соёл ямар нэг хэмжээнд "синтез" болох талаар дурдсан. Мэдээж, синтез гэдэг нь үзэл бодлууд, үнэт зүйлсийн хооронд арифметикийн дундаж байдлаар оршихын нэр биш. Синтез урьдахь үеийн соёлын ололтуудаас боломжтой бүгдийг хадгалан дэвшил хөгжилд тус дөхөм болж, нийгмийн бүтцэд яв цав "сууж өгөх" замаар хувирган өөрчлөх хүчээ бататгах ёстой ажээ. Жишээ нь, төрийг дээдлэх, төрийн үйл хэрэгт үнэнч зүтгэх төрт ёсны уламжлалаа барууны улстөрийн ардчилалтай зүй зохистой хослуулж болохгүй гэх газаргүй. Өнөөгийн улстөрийн онцлог хариуцлагын ёс зүй байх ёстойг өрнөдөд ч хүлээн зөвшөөрдөг. Энэ нь юуны

өмнө бид өөрсдийн итгэл үнэмшлээрээ үйлдлээ хийх төдийгүй тэр үйлдлээс гарч болох бүх үр дагаварыг анхаарч, нягт цэгнэн үзэх шаардлагыг дэвшүүлэн тавьдаг. Түүний дээр бид итгэл үнэмшлээ байнга шүүмжлэлтэй эрэгцүүлэн тунгааж, мухар сүсэг, гаднын зүсэн бүрийн тулгалт, нөлөөллөөс "цэвэрлэж" байх учиртай гэдэг. Макс Вебер итгэл үнэмшил, хариуцлагын ёс зүй нийлж байж жинхэнэ хүнийг, "улстөрийн авьяастай хүнийг" төлөвшүүлэн, бие биеэ харилцан нөхөж байдаг тухай "Улстөр бол мэргэшил мөн" зохиолдоо тэмдэглэсэн байдаг.

Дээр дурдсан бүхнийг шинжиж ажихад өнөөгийн Монголын нийгэм, бүлэг давхарга, хувь хүний улстөрийн чиг баримжаа, үйл байдал алаг цоогдуухан, ардчиллын сонгодог утгаар ерөнхийдөө шинэ үнэт зүйлс, чиг баримжаа, итгэл үнэмшил, үйл байдал тийш хандаж, төлөвших чигтээ явж байна гэх үндэстэй. Өөрөөр хэлбэл, нийгмийн ухамсар уламжлалт үнэт зүйлс, социалист маягийн итгэл үнэмшил, либерал ардчилсан үзэл бодол өөр хоорондоо зөрчилдөн зэрэгцэн оршиж байгаагаар тодорхойлогдож байна.

Шилжилтийн үед нийгмийн шударга ёсны талаархи үнэлгээ улстөр, эдийг засаг, оюун санаа, сэтгэл зүйн олон хүчин зүйлийн нөлөөгөөр доошилсон бөгөөд үүнд өмнөх үеийн тэгшитгэн хуваарилах болхи төсөөлөл ч нөлөөлсөн байж таарна. Гэвч өнөөгийн шатанд нийгмийн улстөрийн ухамсар либерал үнэт зүйлсийн үндсэн дээр захиран тушаах систем, утопи үзэл сургаалийг дөнгөж үгүйсгэх алхамууд хийгээд байгаа нөхцөлд нийгмийн шударга ёсны талаар уламжлалт болон социалист төсөөлөл этатист ухамсартай шүтэлцэн оршсоор байна.

Нийгмийн бүх харилцааны өөрчлөлт шинэчлэлийн дүнд ардчилах үйл явц гүнзгийрэн бэхжих хандлагатай байна. Нийгэмд улстөрийн үндсэн институтууд, үнэт зүйлс, улстөрийн тоглоомын дүрмийн талаар улстөрийн хүчнүүд, иргэд харилцан зөвшлийн тодорхой төвшинд хүрсэн байна. Хэрэг дээрээ улстөрийн үйл явцын нөлөө бүхий бүх оролцогчид зах зээлийн эдийн засаг, эрх зүйт төр, дэлхийн хамтын нийгэмлэгтэй хамтрах санаа нэг буй. Үндсэндээ зөрчлийн хэв маягаас зөвшилцлийн улстөрийн соёл руу хандаж байна. Гэхдээ энэ нь монголын нийгэмд ардчилсан, тулхтай улс төрийн соёл бүрэн боловсорчээ гэсэн хэрэг хараахан биш нь ойлгомжтой. Монголын улстөрийн соёлын янз бүрийн элементүүд, дэд соёлууд зүгшрэн, өөр хоорондоо шүтэн барилдсан харилцан холбоо бүхий бүхэл бүтэн цогц систем болж чадаагүй байна. Өнөөдөр монголын улстөрийн соёлыг шууд этатист, эсвэл зах зээлийн гэж аль нэгээр нь тодорхойлж хэлэхэд бэрхшээлтэй.

Өрнийн үнэт зүйлсийг ямар ч шүүлт, шүүмжлэлгүй хүлээн авч байгаа нь улстөрийн соёлыг дууриамал, хуулбарласан шинжтэй болгож байна. Ардчиллын нэрт судлаач С.Хантингтон "Өнөөдөр Зүүн Азийнхан өөрсдийн эдийн засгийн гайхшруулсан хөгжлийг барууны соёлыг оруулж ирснээр биш, харин өөрийн унаган соёлдоо үнэнч байдгаар тайлбарладаг. Тэд Өрнөтэй ижил болсондоо биш, харин түүнээс ялгаатай үлдсэндээ амжилт олсон гэж баталдаг" [Хантингтон, 1997, с.167] хэмээн бичсэн байдаг билээ.

Хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсээс авч хэрэглэх нь хэвийн зүйл боловч аливааг мухар сохроор хуулбарлаж бас болохгүй. Тухайлбал, өнөөдөр бид өрнийн эд материал, оюунсанааны бүтээгдхүүнүүдийг бэлнээр хэрэглэх, зуучлан түгээх, "рекламдах" төдий байгаа гэхэд хилсдэхгүй. Судлаачид өрнөдийн нийгмийн постматериал үнэт зүйлсийн талаар их ярих болов. Гэхдээ үүнийг гагцхүү өндөр аж үйлдвэржсэн ардчилсан нийгмийн зүй ёсны үзэгдэл болохыг цохон тэмдэглэж байгааг анзаарахгүй байж болохгүй. Манай нийгэмд түүний тодорхой тусгал байхыг үгүйсгэхгүй ч улстөрөөс өгсүүлээд ахуйн элдэв хээнцэр хэрэглээ, кино, дуу хөгжим, реклам сурталчилгаа, чөлөөт цаг гэх мэтэд барууныг хэт дууриадаг нь өнгөц харахад улс хөгжөөд, амьдрал сайжраад буй мэт хуурамч сэтгэгдэл төрүүлэх болзоогүй. Бусдын юмаар өнөөдрийг аргацаадаг юмаа гэхэд

маргаашийг үл чадмой. Бид өөрсдөө л оюунаа дайчилж, гараа хөдөлгөж хөлсөө дуслуулан хийж бүтээж чадсан цагт хөгжиж чадна.

Жишээ нь, Америк бол ардчиллын өлгий, иймд зүсэн бүрийн хүчирхийллээр дүүрэн киног нь манай хүүхэд залуучууд өдөр бүр "шимтэн" үзэх нь зөв, эсвэл ер нь хувийн эрх чөлөө монголд "задгайдуу" байхдаа зүгээр гэх аргагүй. Тэгвэл энэхүү америк хэв маяг Монголд байтугай Америкт өөрт нь ч "гай тарьдагийг" хэн байг гэхэв. Учир нь 100 мянган хүн ам тутамд ногдох хоригдлын тоогоороо энэ улс дэлхийд толгой цохидог гэдэг [Slann, 1998, p.62].

Тэгвэл Амаерикаас гадна улстөрийн шилжилтийн утгаараа ч, газар орны байршил, түүх, соёл, сэтгэхүй талаасаа ч Зүүн Өмнөд Азитай өөрсдийгөө жишин харьцуулж, суралцвал бас болох билээ. Тэндхийн ардчиллын онцлогийг хамтын шинж, нийгмийн үүрэг хариуцлагыг шаардсан бодлого, хамтын ажиллагаа тодорхойлдог. Эдгээр орнууд дахь ардчилал өрнийхийг бодвол иргэдээсээ илүү чанд сахилга, дуулгавартай байдлыг шаардаж "цаадуул" нь ч хүлээн авдаг бололтой. Ингэснээр ардчиллыг өрнөдийнхөөс учир зүггүй дордуулчихсан зүйлгүй агаад харин ч иргэд нь гэмт хэрэг, хүчирхийлэл багатай орчинд сэтгэл өөг аж төрдөг ажээ. Америкийн нэгэн судлаач хот-улсаа цэвэр цэмцгэр байлгахаар бохь зажихаыг хориглосон шийдвэрийн хувьд жишээ нь, ихэнх америкчууд шуугиан дэгдээж болох байсан бол харин Сингапурт тайван хүлээн авсныг тэмдэглэсэн байдаг. Япон улсад хувьдаа галт зэвсэг эзэмших эрхийг бүр 1588 онд хоригложээ. Ардчиллах үйл явцын сүүлийн хагас зуун жилд энэ хориг өргөн дэмжигдсэн хэвээр байгаагаар үл барам Бууны үндэсний нийгэмлэг нь 49 галт зэвсэг хувь хүний гар дээр байгаад сэтгэл дундуур байдаг юм байна [Slann, 1998, p.58-59]. Эндээс үзэхэд манайд бохь, буу сэлтийг ор тас хориглодоггүй юмаа гэхэд нийгмийн дэг журам бол хувь хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулахад шийдвэрлэх нөлөөтэйг иш үндэс болгож, иргэдийнхээ амь нас, аюулгүй байдлыг хамгаалах талаар хийх ажил ардчилагдаж буй монгол төрд асар их байгаа нь илэрхий билээ.

Үүнд монголчуудын улстөрийн соёлын үнэт зүйл-хэм хэмжээ болсон төрөө дээдлэн эв эеийг хичээдэг, дэг журам эрх чөлөөг эн тэнцүү үздэг, бусдын эрх ашигт хүндэтгэлтэй ханддаг олон уламжлалаа тэдгээр орнуудын ардчиллын жишээгээр харгалзан үзвээс монгол төрхөө хадгалсан, тулхтай улстөрийн соёлыг төлөвшүүлэхэд нааштай нөлөөлөх буйзаа.

Эдүгээ зарим судлаачид улстөр, тухайлбал улстөрийн институтүүд чухам юу хийж чадах вэ гэдгийг түүнийг хүрээлэн байдаг орчноос илүүтэй анхаарах хэрэгтэй гэж үздэг. Гэвч энэ нь ардчилалд шилжих үйл явцыг судлахад улстөрийн соёлын хандлагын ач холбогдлыг үгүйсгэсэн хэрэг биш байх. Улстөрийн соёлыг шинэчлэн төлөвшүүлэхгүйгээр ардчилалд шилжих аргагүй. Гэхдээ үндэстэн бүрийн соёлд ардчилалтай нийцэх, бас нийцэхгүй үнэт зүйлс байдгийг тооцох учиртай. Гэвч аль ч соёлд нэгэн адил эрх зүйн засаглал, хуулийн хариуцлага, засаг төрийн байгууллагуудын шаргуу үйл ажиллагаа, ёс зүйн хүчин зүйлийг харгалзахгүй бол ардчилах үйл явц эрх, эрх чөлөө, эрх зүйт төрийн тухай хоосон ярианаас хэтэрдэггүй гэдэг нь үнэн бололтой. Бидний зорилго бол ардчиллын үнэт зүйлсийн хүрээнд монголын улстөрийн сэтгэлгээний онцлог, оюуны баялаг соёлын үнэтэй цэнтэйг хадгалах, сэргээх замаар уламжлалт улстөрийн соёлоо шинэтгэхэд оршиж байгаа билээ. Учир нь өвөг дээдсийн өв төр ёс, өнөөгийн улстөрийн соёлын хооронд хүйн холбоо үл тасрах ажгуу.



**Abstract:**

The functioning of political institutions at least partially reflects the attitudes, norms, expectations of the citizenry. To understand the tendencies for present and future behavior in a nation, we must begin with public attitudes toward politics and the role within the political system - what we call a nation's political culture. Mongolia has a long-term tradition of the unique statehood. The political culture for our country is critical element in understanding politics across time. Distinctive features for that political culture are feelings of patriotism, group solidarity, sense of duty, respectfulness to the state, emotional life to traditions. People tend to see government as a protector of the community from all forms of evil and believed to bring good luck. According more to the ties of patronage leaders are expected to be benevolent, kind, sympathetic figures who inspire commitment. Nor is political culture is unchangeable. New experiences of Mongolian political system in transition to democracy change the attitudes of individuals. Participants, subjects, parochials describe the citizens' role in the political process. Such a distribution provides enough political activists to ensure competition between political parties and sizable voter turnout. Mongolian political culture nowadays has been trend toward democratization and marketization. But there are many problems in political socialization. Author considered main way out of that situation synthesis political values of mongols with Western.

**Эшлэл**

- Almond.G., Verba S. 1963. The Civic Culture: Political Attitudes and Democracy in Five Nations. Princeton.
- Ё.Довчин. Степная политическая культура. СПб., 2000.
- Almond.G., Verba S. 1980. The Civic Culture Revisited. Boston.
- Насилов А.Д. 18 степных законов - памятник монгольского феодального права XVI-XVII вв. Л., 1987.
- Уолкер С.С. Чингиз-хан. Ростов-на Дону. 1998.
- Б.Даш-Ёндон Орчин үеийн монголын нийгмийн хүмүн бүтэц, оюуны амьдралын тухайд. "Манай монгол" сэтгүүл. 1999. № 2.
- Ё.Довчин. Улстөрийн соёлын уламжлал шинэчлэлийн асуудалд. Альтернатив сэтгүүл. УБ., 2003. №1.
- Капустин В.Г. Демократия и справедливость. // Полис., 1992. № 1-2.
- Токвиль А.де. Демократия в Америке. М., 1992.
- Хантингтон С. Запад уникален, но не универсален. // Международная экономика и международные отношения. 1997. № 8.
- Slann M. 1998. Introduction to Politics : Coverments and Nations in the Post Cold War Era. McGraw-Hill.,